



Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (YERP) төсөл

©ILO/2024

Товч танилцуулга



Түншлэгч талууд:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
- БНСУ-ын Хөдөлмөр үйлчилгээний агентлаг (KLES),
- БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн үйлчилгээний агентлаг (KEIS)
- Монголын ноос, ноолуурын холбоо,
- Ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагууд,
- Монголын Хөнгөн үйлдвэрийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоо,
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагууд
- Сонгогдсон үйлдвэр, ААНБ-ууд



Санхүүжилт:

Бүгд Найрамдах Солонгос Улсын
Засгийн газар



Төсөл хэрэгжих хугацаа:

2024 оны 7-р сараас 2026 оны 12-р сар



Зорилтот бүлэг:

Ноос, ноолуур, болон зочлох үйлчилгээний салбарын ажил олгогчид, залуу ажиллагчид.



Төсөл хэрэгжих улс:

Монгол Улс

Үндэслэл

Монгол Улсад техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдлэг, ур чадвар ажил олгогчийн хүлээлтэд нийцэхгүй байх, ажил олгогч, залуу ажилтны хооронд соёл, ойлголтын зөрүү их байгаа бөгөөд энэ шалтгааны улмаас олон мянган залуучууд ажилгүй, эсвэл ажлын байрандаа тогтвортой ажиллаж чадахгүйд хүрч байна. Тиймээс энэхүү Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь дээр дурдсан тулгамдаж буй асуудлын шалтгааныг тодорхойлж, ажил олгогч, ажилтны хамтын ажиллагааг сайжруулах замаар шийдэл олж, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Залуучуудын ажилгүйдлийн түвшин Улаанбаатар хот болон төв суурин газарт илүү өндөр бөгөөд энэ асуудал залуу эрэгтэйчүүдэд илүү их тулгамдаж байна. Залуучуудын дунд албан бус хөдөлмөр эрхлэх нь түгээмэл төдийгүй 15-19 насны залуучуудын 80 орчим хувь нь албан бус хөдөлмөр эрхэлдэг гэсэн судалгаа бий.

Засгийн газраас хийсэн судалгаанаас үзэхэд техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөөд 3 жил болж байгаа залуучуудын дөнгөж 40 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна. Ажил олгогчид төгсөгчдийг ажлын байран дээр дахин сургаж, шаардлагатай ур чадварыг олгодог практик их байна.

Ажлын байранд ур чадварын зөрүүнээс гадна ажил олгогч, залуу ажилтны хооронд соёл, хандлага, үе хоорондын ялгаатай байдал сөргөөр нөлөөлж байна. Ажил олгогчдын дунд залуу ажилтныг залуу учраас олон цагаар, ачаалал дааж ажиллана гэсэн хүлээлт түгээмэл байдаг бол залуу ажилтнууд буюу ялангуяа Зэт үеийнхэн (Gen Z) хөдөлмөр, нийгмийн хамгаалал сайтай, хөдөлмөрийн аятай, таатай нөхцөл бүхий уян хатан ажлын байрыг сонгох хандлагатай байдаг. Талуудын зөрүүтэй хүлээлт, хандлага нь ажлаас гарах, бүтээмжийг бууруулах, ажлын байранд маргаан, зөрчил үүсэх шалтгаан болдог байна. Цаашилбал, ажлын байранд залуучуудын хөдөлмөрлөх эрхийг зөрчих явдал түгээмэл тохиолддог. Залуучуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй, нийгмийн даатгалд хамруулахгүй байж, тэднийг албан бус хөдөлмөр эрхлэхэд түлхэж байна.



©ILO/2024

Монгол Улсын Засгийн газар Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогодоо залуучууд зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, бизнес эрхлэх хүсэл сонирхлыг нь дэмжих зорилтыг дэвшүүлсэн. 2001 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулсан бөгөөд уг сангаар дамжуулан залуучуудад ур чадвар олгох сургалт зохион байгуулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бичил бизнест дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монгол Улс нь Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай ОУХБ-ын 122-р конвенцод нэгдэн орсноор бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэх эрхийг хангах үүрэг хүлээсэн. Гэсэн хэдий ч ажил хайгчдын хэрэгцээнд суурилсан хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгож, институцын чадавхыг бэхжүүлэх шаардлага байсаар байна. Эдгээр асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэж чадвал залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой юм.

► Хүлээгдэж буй үр дүн

YEPP төслийн зорилго нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлого, бүтээмж, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлэхэд оршино. Төслийг ноос ноолуур болон зочлох үйлчилгээний салбарт туршин хэрэгжүүлэх бөгөөд эдгээр салбарууд нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

YEPP төсөл нь Засгийн газар, нийгмийн түншлэгч талуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, залуучуудын хөдөлмөрийн нөхцөл, бүтээмжийг урт хугацаанд тогтвортой сайжруулахыг зорьж байгаа юм. Төслийн хүрээнд нотолгоонд суурилсан бодлого, шийдлийг тодорхойлж, залуу ажилтны идэвх санаачилга, оролцоог дэмжиж, ажлын байрны менежментийг сайжруулах сургалтуудыг зохион байгуулна.

Төслийн хүрээнд дараах хоёр үр дүнд хүрсэн байна:

1. 15-29 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэгдсэн байдлыг сайжруулах;
2. Залуучуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих замаар залуучуудын хөдөлмөрийн нөхцөл, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн бодлого, ажлын байрны менежментийг сайжруулах.

Эдгээр арга хэмжээ нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Засгийн газрын зорилттой нийцэж байгаа бөгөөд хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээл дэх залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна.

© Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2025

► Холбоо барих хаяг:

Хочул Шин ОУХБ/БНСУ-ын хамтын ажиллагааны хөтөлбөрийн ахлах зөвлөх И-мэйл хаяг: shin@ilo.org

Мягмарын Жавзандулам
ОУХБ-ын төслийн зохицуулагч
И-мэйл хаяг: myagmar@ilo.org

НҮБ-ын байр, ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчоо Раждамнерн Нок өргөн чөлөө, Бангкок 10200, Тайланд

Нэгдсэн үндэстний байгууллагын гудамж 12, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо Улаанбаатар хот, 14201, Монгол Улс

 www.ilo.org/mongolia

 [Олон улсын хөдөлмөрийн байгууллага - International Labour Organization](#)

 [ilo_mongolia](#)